



I-XII/2021

Тархаасан: 2022 оны 1 дүгээр сарын 12




## Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 2365 (10.3%)-аар өссөн байна

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 онд 25429 болж, өмнөх оноос 2365 (10.3%)-аар өсжээ. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1571 (13.0%), олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 465 (2.6 дахин), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 232 (3.1%)-оор өссөн нь голлон нөлөөлжээ.

Энэ оны 12 дугаар сард 2749 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сараас 940 (25.5%)-өөр буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 726 (33.8%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эрхийн эсрэг гэмт хэрэг 145 (16.5%), хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 86 (61.9%)-гаар буурсан нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1531 хэргийн 118 (7.7%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)-ээр зүйлчлэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2021 онд 118 бүртгэгдсэн нь өмнөх оноос 7 (6.3%)-гоор өсжээ. Харин 2021 оны 12 дугаар сард 13 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сараас 2 (13.3%)-оор буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2021 онд 9526 зөрчил бүртгэгдсэний 7240 (76.0%) зөрчлийг шалган шийдвэрлэжээ.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил өмнөх оноос 780 (7.6%)-аар, шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил 1211 (14.3%)-ээр тус тус буурчээ.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 онд 119 болж, өмнөх оноос 11 (10.2%)-ээр өссөн байна. Харин 2021 оны 12 дугаар сард 13 болж, өмнөх сараас 4 (23.5%)-өөр буурчээ.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2021 онд 1531 болж, өмнөх оноос 393 (34.5%)-аар нэмэгдэж, харин эмэгтэй хүн оролцсон хэрэг 3218 болж, 134 (4.0%)-өөр, хүүхэд оролцсон хэрэг 733 болж, 78 (9.6%)-аар, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 4842 болж, 13 (0.3%)-аар, бүлэглэн үйлдсэн хэрэг 1367 болж, 115 (7.8%)-аар, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 160 болж, 24 (13.0%)-өөр тус тус буурчээ.

ЗУРАГ 2. УЧИРСАН ХОХИРОЛ БОЛОН НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН ХОХИРОЛ, сараар, тэрбум төгрөгөөр



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2021 онд 180.3 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 90.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 74.6 (29.3%) тэрбум төгрөгөөр буурч, харин нөхөн төлүүлсэн хохирол 8.3 (10.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 3. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ЯЛЛАГДАГЧ, насны бүлгээр, жил бүрийн эцсийн байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2021 онд 18078 болж, өмнөх оноос 1411 (8.5%)-ээр өсжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 921 (5.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 2927 (16.2%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 1. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН, ГЭМТСЭН, НАС БАРСАН ХҮН, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эцсийн байдлаар

Үзүүлэлт	Хохирсон хүн		Гэмтсэн хүн		Нас барсан хүн	
	2020	2021	2020	2021	2020	2021
	7 хүртэлх	155	158	65	77	63
8-17	1 026	1 207	451	473	36	27
18-29	5 934	6 531	2 480	2 349	90	95
30-39	7 344	8 162	2 635	2 733	131	177
40-49	4 724	5 232	1 443	1 585	153	147
50-59	2 707	2 590	815	773	126	120
60-69	931	879	235	233	46	40
70, түүнээс дээш	229	235	51	76	25	21
Улсын дүн	23 050	24 994	8 175	8 299	670	683
Эмэгтэй	9 421	11 275	3 127	3 070	170	176

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2021 онд 25.0 мянга болж, 1365 (5.5%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 11275 (45.1%) нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэргийн улмаас 2021 онд 8299 хүн гэмтэж, 683 хүн нас барсан нь өмнөх оноос гэмтсэн хүн 124 (1.5%)-өөр, нас барсан хүн 13 (1.9%)-аар өсжээ.


Улсын хэмжээнд 2021 онд 70.5 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 15.3 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оноос эрүүлжүүлэгдсэн хүн 23.4 (24.9%) мянгаар, баривчлагдсан хүн 1.6 (9.6%) мянгаар буурсан байна.

**Авлигатай тэмцэх газарт 2021 онд 335 авлигын хэрэг бүртгэгджээ**

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2021 онд 335 авлигын хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 21 (6.7%)-ээр өсжээ. Авлигын гэмт хэрэг өмнөх оноос өсөхөд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 18 (8.2%)-аар, хахууль авах гэмт хэрэг 7 (10.4%)-гоор, хахууль өгөх гэмт хэрэг 5 (12.5%)-аар, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг 3 (2.0 дахин)-аар, үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэг 3 (42.9%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Бүртгэгдсэн 335 авлигын хавтаст хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад 237 (63.2%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 74 (19.7%) нь хахууль авах гэмт хэрэг, 45 (12.0%) нь хахууль өгөх гэмт хэрэг, 10 (2.7%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 6 (1.6%) нь хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг, 3 (0.8%) нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг байна.

ЗУРАГ 4. АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ, хэргийн төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар



## Ойлголт, тодорхойлолт

**Гэмт хэрэг:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

**16. түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг:** Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.



**Хохирогч:** Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

**Гэмт хэргийн хохирол:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

**Яллагдагч:** Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

**Авлигын гэмт хэрэг:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт зааснаар авлигын гэмт хэрэгт эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт үйлдлүүдийг хамруулна.

## Эх үүсвэр:

Цагдаагийн Ерөнхий Газрын мэдээлэл

## Ангилал, код:

Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал

## Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

## Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 02 дугаар сарын 14

Нийгмийн статистикийн газрын  
дарга А.Амарбал  
Утас: (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын  
статистикч Ц.Дулмаа  
Утас: (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212